

**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**ГАРЧИГ**

Бүлэг 1. Төслийн товч танилцуулга .....	2
1.1. Төслийн нэр .....	2
1.2. Ашигт малтмалын дугаар .....	2
1.3. Төсөл хэрэгжүүлэгч .....	2
1.4. Төслийн байршил .....	2
1.5. Ордын нөөцийн тооцоо.....	4
1.6. Олборлолтын ажил.....	6
1.7. Баяжуулалт.....	6
1.8. Эдийн засаг .....	7
1.9. Ордын өнөөгийн байдал, цаашдын ашиглалт .....	7
1.10. Тэсэлгээний ажилд шаардагдах тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгсэл: .....	9
1.11. Далд уухайн ашиглах хугацаа ба ажиллах горим .....	10
1.12. Төслийн үндсэн тоног төхөөрөмж.....	10
1.13. Гадаад болон дотоод тээвэр .....	11
Бүлэг 2. төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	12
2.1. Газарзүйн мужлалаар: .....	12
2.2. Ус зүйн хувьд:.....	12
2.3. Хөрсний хувьд: .....	12
2.4. Ургамлын хувьд: .....	12
2.5. Ан амьтны хувьд: .....	12
2.6. Цаг агаарын хувьд: .....	13
2.7. Дэд бүтэц:.....	13
2.8. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдал .....	13
Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....	14
3.1. Болзошгүй сөрөг нөлөөллүүд.....	14
3.2. Гол сөрөг нөлөөлөл .....	15
Бүлэг 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ .....	16
Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	17
Бүлэг 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	18
Бүлэг 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	19
Бүлэг 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	20
Бүлэг 9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
Бүлэг 10. Химийн бодис, ОСОЛ эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
Бүлэг 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	24
Бүлэг 12. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр .....	25
Бүлэг 13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	28
Бүлэг 14. Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	29
Бүлэг 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	30

# “Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны

## Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

### БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

#### 1.1. Төслийн нэр

Төслийн нэр: “Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”

#### 1.2. Ашигт малтмалын дугаар

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-001455

#### 1.3. Төсөл хэрэгжүүлэгч

Төсөл хэрэгжүүлэгч: “Үнэн-Анд” ХХК,


- Регистрийн дугаар: 2885565;
- Улсын бүртгэлийн дугаар: 9011038138;
- Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 32-96 тоот;
- Утас: 88114980.

#### 1.4. Төслийн байршил

“Үнэн-Анд” ХХК-ий Мануулт хайлуур жоншны орд нь засаг захиргааны харьяаллын хувьд Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр-Ус багийн нутаг дэвсгэрт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 320 км-т, Баянжаргалан сумаас өмнө зүгт 28 км-т, Чойрын төмөр замын өртөөнөөс баруун урагш 110 км-т, төв Мандалговь хотоос зүүн зүгт 135 км-т тус тус байрлана.


Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

№	АМТЗ-ийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	MV-001455	107°56'31.6"E	45°29'41.55"N
2		107°56'1.58"E	45°29'41.56"N
3		107°56'1.49"E	45°30'1.61"N
4		107°56'31.5"E	45°30'1.61"N




Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршил

“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 2. Төслийн талбайн хүрээлэн буй орчны төлөв байдлыг байрзүйн зургаар харуулав (М 1:100000)



Зураг 3. Төслийн талбайн орчны төлөв байдал

**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



*Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж*



*Зураг 5. Далд уурхайн босоо гол амны цамхаг*



*Зураг 6. Уурхайг тосгон*

### **1.5. Ордын нөөцийн тооцоо**

Монгол Улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2012 оны 09 сарын 06-ны өдрийн хурлын хуралдааны ХХ-20-05 дугаар дүгнэлтийг үндэслэн (Ордын нөөц 2011 оны 06-р дугаар сарын 01-ний байдлаарх) Мануултын хайлуур жоншны хүдрийн бодитой (В) нөөцийг 116 мян.тн-оор, 45.61%-ийн агуулгатай хайлуур жоншны бодитой (В) нөөцийг 52.91 мян.тн-оор, хайлуур жоншны хүдрийн боломжтой (С) нөөцийг 40.27 тн-оор 40.52%-ийн агуулгатай хайлуур жоншны боломжтой (С) нөөцийг 16.32 тн-оор, хайлуур жоншны хүдрийн бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 156.28 мян.тн-оор, 44.3%-ийн

**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

агуулгатай хайлуур жоншны бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 69.23 мян.тн-оор нөөцөд бүртгүүлсэн.

**Хүснэгт 2. Ордын анх батлагдсан геологийн нөөц**

Хүдрийн биетийн №	Нөөцийн зэрэглэл	Блокийн бодит талбай, м <sup>2</sup>	Жинхэнэ зузаан, м	Блокийн эзэлхүүн, м <sup>3</sup>	Эзэлхүүн жин, тн/м <sup>3</sup>	Хүдрийн нөөц, тн	Дундаж агуулга, %	CaF <sub>2</sub>
Х.Б-1	1В-1	247.51	7.86	1945.46	2.63	5116.57	45.72	2339.43
	1В-2	360.53	6.66	2401.15	2.63	6315.04	41.55	2623.62
Х.Б-1	1С-1	186.65	5.04	940.74	2.63	2474.14	58.86	1456.28
	1С-2	278.01	7.70	2140.71	2.63	5630.07	39.29	2212.05
	1С-3	312.18	5.40	1685.80	2.63	4433.65	36.59	1622.27
	1С-4	234.65	2.80	657.01	2.63	1727.95	58.32	1007.74
Х.Б-2	2В-1	208.57	3.86	805.78	2.63	2119.21	33.46	709.18
	2В-2	272.17	11.00	2993.85	2.63	7873.83	44.51	3504.59
	2В-3	517.55	9.40	4864.99	2.63	12794.91	42.92	5491.71
Х.Б-2	2С-1	164.54	1.79	294.53	2.63	774.60	21.35	165.38
	2С-2	123.10	3.00	369.30	2.63	971.25	30.91	300.21
	2С-3	93.34	13.00	1213.36	2.63	3191.12	49.70	1585.99
	2С-4	248.33	4.60	1142.31	2.63	3004.29	30.60	919.31
	2С-5	230.37	3.00	691.11	2.63	1817.63	32.33	587.64
Х.Б-3	3В-1	91.00	4.18	380.39	2.63	1000.43	42.23	422.45
	3В-2	160.28	4.52	723.99	2.63	1904.08	40.07	762.99
Х.Б-3	3С-1	40.59	1.00	40.59	2.63	106.75	28.49	30.41
	3С-2	174.50	2.50	436.25	2.63	1147.34	32.69	375.07
	3С-3	196.99	2.08	409.75	2.63	1077.63	34.27	369.31
	3С-4	87.88	1.64	144.12	2.63	379.03	22.24	84.30
Х.Б-4	4В-4	3942.74	3.16	12442.16	2.63	32722.88	44.18	14457.47
Х.Б-5	5В-5	2406.84	4.81	11580.92	2.63	30457.83	49.38	15039.79
Х.Б-6	6В-6	2472.85	2.42	5971.94	2.63	15706.20	48.15	7562.58
Х.Б-4	4С-1	1077.06	1.77	1909.09	2.63	5020.90	49.51	2485.95
Х.Б-5	5С-1	1166.23	1.72	2002.99	2.63	5267.87	29.49	1553.67
Х.Б-6	6С-1	825.84	1.50	1236.69	2.63	3252.49	48.15	1566.08
Нийт В		10680.05	4.13	44110.64	2.63	116010.99	45.61	52913.81
Нийт С		5440.26	2.82	15314.34	2.63	40276.71	40.52	16321.65
Нийт В+С		16120.31	3.69	59424.98	2.63	156287.70	44.30	69235.47

**Хүснэгт 3. Ордын үлдэгдэл геологийн нөөц (2019 оны 01-р сарын 01-ний байдлаар)**

№	Хүдрийн биетийн дугаар	Нөөцийн зэрэглэл	Хүдрийн нөөц	Дундаж агуулга	Эрдсийн нөөц
1	I	В+С	5618.58	41.57	2335.62
2	II	В+С	27107.01	42.01	11388.32
3	III	В+С	5615.26	36.41	2044.53
4	IV	В+С	37743.78	44.89	16943.42
5	V	В+С	35725.70	46.45	16593.46
6	VI	В+С	18958.69	48.15	9128.66
7	Нийт	В+С	130769.03		58434.01

**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**1.6. Олборлолтын ажил**

2023 онд V, VI хүдрийн биетийг нээгч малталт болох босоо гол амыг 1114 м-ийн түвшингээс 1024 м-ийн түвшин хүртэл 90 м малталт нэвтрэнэ. Харин агааржуулалтын босоо гол амыг ил уурхайн ёроолын 1148 м-ийн түвшингээс 1024 м-ийн түвшин хүртэл 124 м урттайгаар нэвтрэхээр төлөвлөж байна.

Харин I хүдрийн биетийг нээгч малталт болох налуу гол ам №1-г  $S_n=11.2$  м<sup>2</sup> хөндлөн огтлолын талбайтайгаар ил уурхайн ёроолын  $Y=729295.9$   $X=5042536.5$  солбицлын 1148 м-ийн түвшинд 40 м урт малталт тус тус нэвтрэхээр төлөвлөж байна.

*Хүснэгт 4. 2023 онд нэвтрэх малталтын жагсаалт*

№	Малталтууд	Хөндлөн огтлолын талбай, м <sup>2</sup>	Малталтын урт, м
1	Босоо гол ам	9.1	90
2	Агааржуулалтын босоо гол ам	9.1	124
3	Квершлаг	6.5	20
4	Штрек	11.2	40
5	Налуу малталт	11.2	40

2019 онд В'-3, В'-4 блокуудыг таллан олборлосон ба 2023 онд гүйцээн олборлохоор төлөвлөв. 2023 онд В'-1, В'-3, В'-4 блокуудад олборлолтын үйл ажиллагаа явуулж нийт 38.626 мян.тн хүдэр /хүдэр дэх эрдсийн хэмжээ 15069.9 тн/ олборлоно.

2023 онд I хүдрийн биетээс 3.859 мян.тн, II хүдрийн 5.761 мян.тн, IV хүдрийн биетээс 29.0 мян.тн хүдэр олборлоно.

**1.7. Баяжуулалт**

Уурхайгаас олборлосон хүдрээсээ бүхэллэг баяжмалыг гар аргаар ялган авч, үлдсэн хүдрийг гравитацийн аргаар баяжуулна. 2023 онд нийт 38.626 мян.тн хүдэр олборлож гар аргаар 4.1716 мян.тн ФК-75 маркийн бүхэллэг баяжмал ялган авна. Харин үлдэгдэл хүдрээс 20.8348 мян.тн хүдрийг гравитацийн аргаар баяжуулж ФГ-85 маркийн 5.08318 мян.тн баяжмал гарган авна. Үлдэгдэл 13.61953 мян.тн бага агуулгатай хүдрийг шууд борлуулна. Уурхайгаас олборлосон хүдрийг баяжуулан баяжмалыг овоолго үүсгэн хурааж 7 хоног болгон ачилт хийлгэнэ. Энэхүү баяжмалын түр овоолго нь 1-2 м-ийн өндөртэй ойролцоогоор 100-150 м<sup>2</sup> талбайд байршина.

Далд уурхайн үндсэн /босоо гол ам, квершлаг, налуу гол ам/ ба бэлтгэл /штрек/ малталтыг хоосон чулуулаг дундуур нэвтрэх тул ямар нэгэн нөөцийн блокт хамааруулах боломжгүй юм. Босоо гол амыг хүдрийн биетийн хэвтээ талд газрын гадарга дээрх хүдрийн биетийн гаршаас 25 м зайд хоосон чулуулаг дундуур нэвтрэнэ. Харин тээврийн штрекийг ашиглалтын түвшин бүрт хүдрийн биетийн хэвтээ контактаас 5 м зайд хүдрийн биеттэй параллелиар хоосон чулуулаг дундуур нэвтрэнэ. Харин квершлаг малталтыг босоо гол амнаас тээврийн штрек малталтад перпендикулярар хоосон чулуулаг дундуур нэвтрэнэ. Налуу гол амыг ил уурхайн карьерын ёроолоос хүдрийн биетийн хэвтээ талын контактаар хүдрийн биеттэй параллелиар хоосон чулуулаг дундуур нэвтрэнэ. Малталтаас гарах хоосон чулуулгийн хэмжээ:

- Босоо гол амыг  $S=9.1$  м<sup>2</sup> хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 214 м малталт нэвтрэнэ.  
 $V=s*l=9.1*214=1947.4$  м<sup>3</sup>

## **“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

- Квершлаг малталтыг  $S=6.5$  м<sup>2</sup> хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 20 м малталт нэвтэрнэ.  $V=s*l=6.5*20=130$  м<sup>3</sup>
- Налуу гол амыг  $S=11.16$  м<sup>2</sup> хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 80 м малталт нэвтэрнэ.  $V=s*l=11.16*80=892.8$  м<sup>3</sup>

Малталт нэвтрэлтийн ажлаас нийт  $1947.4+130+892.8=2970.2$  м<sup>3</sup> хөрс гарна.

### **1.8. Эдийн засаг**

2023 онд уурхайд 50-н ажилтан ажиллана. ФК-75 ба ФГ-85 маркийн баяжмалыг БНХАУ-д борлуулах бол бага агуулгатай хүдрийг “Говь Аргатай девелопмент” ХХК-д борлуулна. 2023 онд нийт 4217.41 сая.төг-ийн борлуулалт хийж 3643.93 сая.төг-ийн зардал гарган ажиллана.

### **1.9. Ордын өнөөгийн байдал, цаашдын ашиглалт**

“Үнэн-Анд” ХХК нь 2013-2028 оны хооронд ордын I, II хүдрийн биетүүдийг ил уурхайн аргаар олборлох ашиглалтын үйл ажиллагаа явуулсан. Харин IV, V, VI хүдрийн биетүүдийг нээх олборлох зорилгоор нээгч малталт болох босоо гол ам №1-ийг  $S_n=9.1$  м<sup>2</sup> хөндлөн огтлолын талбайтайгаар  $Y=729129.9$   $X=5042493.5$  хавтгайн солбицлоос газрын гадаргын 1171 м-ийн түвшингээс 1124 м-ийн түвшин хүртэл 47 м гүн малталт нэвтэрсэн. Мөн IV хүдрийн биетийг эрэл хайгуул хийх, олборлох нээх зорилгоор ил уурхайн ухашын хойд ёроолоос  $S_n=11.2$  м<sup>2</sup> хөндлөн огтлолын талбайтайгаар 40 м урт налуу гол ам нэвтэрсэн. 2019 онд IV хүдрийн биетийн нээгч малталт болох босоо гол амыг үргэлжлүүлэн 1114 м-ийн түвшин хүртэл 10 м нэвтэрч, түүний дараагаар 91 м штрек малталтыг нэвтэрсэн.

Ордыг цаашид ил уурхайн аргаар ашиглахад хүндрэлтэй /хөрс хуулалт ихтэй/ болсон тул цаашид далд уурхайн аргаар ашиглахаар төлөвлөж байна. 2018-2019 онд нэвтэрсэн IV, V, VI хүдрийн биетийг нээгч малталт босоо гол амыг үргэлжлүүлэн 2023 онд 1114 м-ийн түвшингээс 1024 м-ийн түвшин хүртэл 90 м малталт нэвтэрнэ. Харин агааржуулалтын босоо гол амыг ил уурхайн ёроолын 1148 м-ийн түвшингээс 1024 м-ийн түвшин хүртэл 124 м урттайгаар нэвтрэхээр төлөвлөж байна.

Харин I хүдрийн биетийг нээгч малталт болох хэвтээ гол ам №1-г  $S_n=11.2$  м<sup>2</sup> хөндлөн огтлолын талбайтайгаар ил уурхайн ёроолын  $Y=729295.9$   $X=5042536.5$  солбицлын 1148 м-ийн түвшинд 40 м урт малталт тус тус нэвтрэхээр төлөвлөж байна.

**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

*Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо*

№	Нөөцийн блокийн дугаар	Анх батлагдсан нөөц /2012.10.03, №584/							2013-2018 онд олборлосон нөөц			2019.01.01-ний байдлаарх үлдэгдэл нөөц			Олборлолтод өртөхгүй нөөц			Далд уурхайн хүрэн дэх геологийн нөөц						
		Блокийн талбай	Дундаж зузаан	Блокийн эзлэхүүн	Эзлэхүүн жин	Хүдрийн нөөц	Дундаж агуулга	Эрдсийн нөөц	Хүдрийн нөөц	Дундаж агуулга	Эрдсийн нөөц	Хүдрийн нөөц	Дундаж агуулга	Эрдсийн нөөц	Хүдрийн нөөц	Дундаж агуулга	Эрдсийн нөөц	Блокийн талбай	Дундаж зузаан	Блокийн эзлэхүүн	Эзлэхүүн жин	Хүдрийн нөөц	Дундаж агуулга	Эрдсийн нөөц
		м <sup>2</sup>	м	м <sup>3</sup>	тн/м <sup>3</sup>	тн	%	тн	тн	%	тн	тн	%	тн	тн	%	тн	м <sup>2</sup>	м	м <sup>3</sup>	тн/м <sup>3</sup>	тн	%	тн
1	I-B-1	247.5	7.86	1945.5	2.63	5116.6	45.72	2339.4	5116.6	45.72	2339.4													
2	I-B-2	360.5	6.66	2401.2	2.63	6315.0	41.55	2623.6	4634.4	45.41	2104.4	1680.6	30.90	519.2	92.1	30.90	28.4	155.6	3.88	604.0	2.63	1588.6	30.90	490.8
3	I-C-1	186.7	5.04	940.7	2.63	2474.1	58.86	1456.3	2474.1	31.94	1456.3													
4	I-C-2	278.0	7.70	2140.7	2.63	5630.1	39.29	2212.1	5630.1	44.95	2212.1													
5	I-C-3	312.2	5.40	1685.8	2.63	4433.7	36.59	1622.3	2223.6	36.59	813.6	2210.0	36.59	808.6	579.5	36.59	212.0	122.4	5.07	620.0	2.63	1630.5	36.59	596.6
6	I-C-4	234.7	2.80	657.0	2.63	1728.0	58.32	1007.7				1728.0	58.32	1007.7				234.7	2.80	657.0	2.63	1728.0	58.32	1007.7
7	II-B-1	208.6	3.86	805.8	2.63	2119.2	33.46	709.2	2119.2	45.21	709.2													
8	II-B-2	272.2	11.00	2993.9	2.63	7873.8	44.51	3504.6	1574.8	44.51	700.9	6299.1	44.51	2803.7				225.1	10.64	2395.1	2.63	6299.1	44.51	2803.7
9	II-B-3	517.6	9.40	4865.0	2.63	12794.9	42.92	5491.7				12794.9	42.92	5491.7				517.6	9.40	4865.0	2.63	12794.9	42.92	5491.7
10	II-C-1	164.5	1.79	294.5	2.63	774.6	21.35	165.4	774.6	32.46	165.4													
11	II-C-2	123.1	3.00	369.3	2.63	971.3	30.91	300.2	971.3	36.06	300.2													
12	II-C-3	93.3	13.00	1213.4	2.63	3191.1	49.70	1586.0				3191.1	49.70	1586.0				93.3	13.00	1213.4	2.63	3191.1	49.70	1586.0
13	II-C-4	248.3	4.60	1142.3	2.63	3004.3	30.60	919.3				3004.3	30.60	919.3				248.3	4.60	1142.3	2.63	3004.3	30.60	919.3
14	II-C-5	230.4	3.00	691.1	2.63	1817.6	32.33	587.6				1817.6	32.33	587.6				230.4	3.00	691.1	2.63	1817.6	32.33	587.6
15	III-B-1	91.0	4.18	380.4	2.63	1000.4	42.23	422.5				1000.4	42.23	422.5				91.0	4.18	380.4	2.63	1000.4	42.23	422.5
16	III-B-2	160.3	4.52	724.0	2.63	1904.1	40.07	763.0				1904.1	40.07	763.0				160.3	4.52	724.0	2.63	1904.1	40.07	763.0
17	III-C-1	40.6	1.00	40.6	2.63	106.8	28.49	30.4				106.8	28.49	30.4				40.6	1.00	40.6	2.63	106.8	28.49	30.4
18	III-C-2	174.5	2.50	436.3	2.63	1147.3	32.69	375.1				1147.3	32.69	375.1				174.5	2.50	436.3	2.63	1147.3	32.69	375.1
19	III-C-3	197.0	2.08	409.7	2.63	1077.6	34.27	369.3				1077.6	34.27	369.3				197.0	2.08	409.7	2.63	1077.6	34.27	369.3
20	III-C-4	87.9	1.64	144.1	2.63	379.0	22.24	84.3				379.0	22.24	84.3				87.9	1.64	144.1	2.63	379.0	22.24	84.3
21	IV-B-1	3942.7	3.16	12442.2	2.63	32722.9	44.18	14457.5				32722.9	44.18	14457.5	636.4	44.18	281.2	3942.7	3.09	12200.2	2.63	32086.4	44.18	14176.3
22	IV-C-1	1077.1	1.77	1909.1	2.63	5020.9	49.51	2486.0				5020.9	49.51	2486.0	1830.2	49.51	906.2	1077.1	1.13	1213.2	2.63	3190.7	49.51	1579.8
23	V-B-1	2406.8	4.81	11580.9	2.63	30457.8	49.38	15039.8				30457.8	49.38	15039.8	0.0	0.00	0.0	2406.8	4.81	11580.9	2.63	30457.8	49.38	15039.8
24	V-C-1	1166.2	1.72	2003.0	2.63	5267.9	29.49	1553.7				5267.9	29.49	1553.7	75.4	29.49	22.2	1149.5	1.72	1974.3	2.63	5192.5	29.49	1531.4
25	VI-B-1	2472.9	2.42	5971.9	2.63	15706.2	48.15	7562.6				15706.2	48.15	7562.6				2472.9	2.42	5971.9	2.63	15706.2	48.15	7562.6
26	VI-C-1	825.8	1.50	1236.7	2.63	3252.5	48.15	1566.1				3252.5	48.15	1566.1				825.8	1.50	1236.7	2.63	3252.5	48.15	1566.1
27	B	10680.0	4.13	44110.6	2.63	116011.0	45.61	52913.8	13445.0	43.54	5853.9	102566.0	45.88	47059.9	728.5	42.50	309.6	9971.9	3.88	38721.5	2.63	101837.5	45.91	46750.3
28	C	5440.3	2.82	15314.3	2.63	40276.7	40.52	16321.7	12073.7	40.98	4947.6	28203.0	40.33	11374.1	2485.1	45.89	1140.5	4481.4	2.18	9778.7	2.63	25717.9	39.79	10233.7
29	B+C	16120.3	3.69	59425.0	2.63	156287.7	44.30	69235.5	25518.7	42.33	10801.5	130769.0	44.68	58434.0	3213.6	45.12	1450.1	14453.4	3.36	48500.2	2.63	127555.4	44.67	56983.9

№	Далд уурхайн хүрэн дэх геологийн нөөц										Хаягдал			Бохирдол			Үйлдвэрлэлийн нөөцийн зэрэг, дугаар	Үйлдвэрлэлийн нөөц			
	Нөөцийн блокийн дугаар	Ашиглалтын блокийн дугаар	Ашиглалтын блокийн талбай	Хүдрийн биетийн зузаан	Блокийн эзлэхүүн	Эзлэхүүн жин	Хүдэр	Агуулга CaF <sub>2</sub>	Эрдсийн нөөц	Хаягдал	Хүдрийн нөөц		Эрдсийн хэмжээ	Бохирдол	Хүдрийн нөөц			Хүдрийн нөөц	Агуулга CaF <sub>2</sub>	Эрдсийн нөөц	
											м <sup>3</sup>	тн			тн	тн					м <sup>3</sup>
1	I-B-2, I-C-3, I-C-4	Блок 1	512.6	3.67	1881.0	2.63	4947.0	42.35	2095.1	28.76	540.9	1422.6	575.6	9.48	127.0	333.9	B'-1	1467.1	3858.4	39.38	1519.6
2	II-B-2, II-B-3, II-C-3, II-C-4	Блок 2	498.7	10.18	5076.7	2.63	13351.6	44.77	5976.9	31.24	1585.9	4171.0	1841.7	3.50	122.0	321.0	B'-2	3612.8	9501.6	43.52	4135.2
3	II-B-3, II-C-4, II-C-5	Блок 3	816.0	6.41	5230.2	2.63	13755.4	39.34	5411.5	19.29	1009.0	2653.6	1136.7	5.86	247.4	650.6	B'-3	4468.6	11752.4	36.37	4274.8
4	IV-B-1, IV-C-1	Блок 4	5019.8	2.67	13413.4	2.63	35277.2	44.66	15756.1	12.24	1641.7	4317.7	1932.3	13.05	1536.4	4040.6	B'-4	13308.0	35000.1	39.50	13823.7
5	V-B-1, V-C-1	Блок 5	3556.4	3.81	13555.2	2.63	35650.3	46.48	16571.2	9.67	1310.4	3446.4	1408.9	8.79	1076.0	2829.9	B'-5	13320.9	35033.9	43.28	15162.3
6	VI-B-1, VI-C-1	Блок 6	3298.7	2.19	7208.6	2.63	18958.7	48.15	9128.7	11.80	850.6	2237.2	1077.2	15.68	996.9	2621.8	B'-6	7354.9	19343.3	41.62	8051.5
7	III-B-1, III-B-2, III-C-1, III-C-2, II-C-3	Блок 7	377.5	2.87	1084.0	2.63	2850.9	36.98	1054.4	20.26	219.6	577.5	196.3	11.93	103.1	271.1	B'-7	967.5	2544.5	33.72	858.0
	III-B-2, II-C-3, III-C-4	Блок 8	373.7	2.81	1051.1	2.63	2764.4	35.82	990.1	7.35	77.2	203.1	59.4	11.95	116.3	306.0	B'-8	1090.2	2867.2	32.46	930.8
8	Нийт		14453.4	3.36	48500.2	2.63	127555.4	44.67	56983.9	14.92	7235.4	19029.1	8228.1	10.48	4325.1	11375.0		45589.8	119901.3	40.66	48755.9



**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**1.10. Тэсэлгээний ажилд шаардагдах тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгсэл:**

**Хүснэгт 6. Малталт нэвтрэлтийн ӨТА-н дэлгэрэнгүй**

№	Үзүүлэлтүүд	Босоо гол ам	Квершлаг	Тээврийн штрек	Налуу малталт
1	Малталтын хөндлөн огтлолын талбай, м <sup>2</sup>	9.1	6.5	11.16	11.16
2	Тэсрэх бодисын хувийн зарцуулалт, кг/м <sup>3</sup>	2.4	2.8	2.0	2.0
3	Нийт шпурын тоо, шир	26	23	29	29
4	Үүнээс	Цөмлөх	4	4	4
5		Нураах	8	6	8
6		Хэв засах	14	13	17
7	Шпурын гүн, м	Цөмлөх	8	8	8
8		Нураах	14.4	10.8	14.4
9		Хэв засах	25.2	23.4	30.6
10		Нийт	47.6	42.2	53.0
11	Цэнэгийн жин, кг	Цөмлөх	6	6	6
12		Нураах	9.6	7.2	9.6
13		Хэв засах	16.8	15.6	20.4
14	Түгжээсний урт, м	Цөмлөх	2	2	2
15		Нураах	4.8	3.6	4.8
16		Хэв засах	8.4	7.8	10.2
17	Тэсрэх бодисын зарцуулалт, кг/цикл	32.4	28.8	36.0	36.0
18	Нураах уулын цулын хэмжээ, м <sup>3</sup>	13.7	10.4	17.9	17.9
19	1м шпурт ногдох уулын цулын хэмжээ, м/м <sup>3</sup>	3.5	4.1	3.0	3.0
20	1м <sup>3</sup> уулын цулд ноогдох өрөмдлөгийн хэмжээ, м <sup>3</sup> /м	0.3	0.2	0.3	0.3
21	Нийт уулын ажлын хэмжээ, м	214	20	40	40
22	Нэг мөчлөг дэх мөргөцөгийн ахилтын хэмжээ, м	1.5	1.6	1.60	1.60
23	Мөчлөгийн нийт тоо, удаа	143	13	25	25
24	Тэсрэх бодисын нийт зарцуулалт, тн	4.63	0.37	0.90	0.90

**Хүснэгт 7. Малталт нэвтрэлтийн ӨТА-д зарцуулагдах ТБ-н жагсаалт**

№	Үзүүлэлтүүд	Босоо гол ам	Квершлаг	Тээврийн штрек	Налуу малталт	Үндсэн малталт нэвтрэлт	Бэлтгэл малталт нэвтрэлт	Нийт
1	Нийт өрөмдлөгийн урт, мян.м	6.8	0.5	1.3	1.3	8.7	1.3	10.0
2	Нийт тэсрэх бодисын зарцуулалт, тн	4.6	0.4	0.9	0.9	5.9	0.9	6.8
3	Нонель систем 5м, шир	3718	299	725	725	4742.0	725.0	5467
4	Цахилгаан тэслүүр /ЭД/, шир	715	65	125	125	905.0	125.0	1030
5	Цочир дамжуулах шижим /ДША/, м	1430	130	250	250	1810	250	2060
6	Бялт тэслүүр /КД/, шир	3718	299	725	725	4742	725	5467
7	Гал дамжуулах шижим, м	18590	1495	3625	3625	23710	3625	27335

**Хүснэгт 8. 2023 онд зарцуулах нийт тэсрэх бодисын жагсаалт**

№	Үзүүлэлтүүд	Малталт нэвтрэлт	Хүдэр нураалт	Нийт
1	Нийт өрөмдлөгийн урт, мян.м	10,01	57,586	67,59
2	Нийт тэсрэх бодисын зарцуулалт, тн	6,81	38,4	45,20
3	Нонель систем 5м, шир	5467	31,992	37459
4	Цахилгаан тэслүүр /ЭД/, шир	1030	13330	14360
5	Цочир дамжуулах шижим /ДША/, м	2060	26660	28720
6	Бялт тэслүүр /КД/, шир	5467	31992	37459
7	Гал дамжуулах шижим, м	27335	159960	187295

**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**Хүдэр нураалтын ажлын технологи:** Мөргөцөгт шпур өрөмдөх ажлыг 2-4 хүний бүрэлдэхүүнтэйгээр гар перфератораар ӨТА-ын паспортын дагуу хийж гүйцэтгэнэ. Мөргөцөгт шпур өрөмдөж дууссаны дараа ээлжийн мастерын зөвшөөрлийн дагуу тэсрэх материалыг авч шпурыг цэнэглэж бусад мөргөцөгөөс хүмүүсийг гаргаж тэсэлгээний ажлыг явуулна.

Тэсэлгээний ажлын дараа уурхайн ээлжийн мастер, тухайн ээлжийн ахлагчийн хамт агааржуулалтын байдлыг шалгаж ачилтын орт малталтаас хүдрийг ачигч машинаар тэргэнцэрт ачиж ашиглалтын системийн дагуу блок дахь сийрэгжсэн хүдрийг суулгаж дараагийн ээлжийг мөргөцөгт шпур өрөмдөх ажлыг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ дарааллаар хүдэр нураалтын ажлын цикл үргэлжилнэ.

**1.11. Далд уурхайн ашиглах хугацаа ба ажиллах горим**

Далд уурхайн ажиллах горим: мануултын хайлуур жоншны далд уурхайн ажиллах горимыг дараах байдлаар авч байна. Үүнд:

- Жилийн нийт хоног 365 хоног;
- Үндэсний баяр, ёслолын хоног 14 хоног;
- Засвар үйлчилгээ, бусад 51 хоног;
- Уурхайн жилд ажиллавал зохих хоног 300 хоног;
- Хоногт ажиллах ээлжийн тоо 3 ээлж;
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг тус тус байна.

**1.12. Төслийн үндсэн тоног төхөөрөмж**

*Хүснэгт 9. Төслийн үндсэн тоног төхөөрөмж*

Д/д	Нэр төрөл	Тоо
<b>Далд уурхайн тоног төхөөрөмж</b>		
1	Нэвтрэлтийн цамхаг	1
2	Өргөх цамхаг	2
3	Өргөх төхөөрөмж	2
4	Клеть	2
5	Өргөх хөнөг	2
6	Далд уурхайн зүтгүүр	1
7	Тэргэнцэр	8
8	Гар өрмийн машин	10
9	Вентилятор /суурин/	2
10	Вентилятор /зөөврийн/	4
11	Компрессор	2
12	Далд уурхайн утгуурт ачигч	1
13	Далд уурхайн автосамосвал	2
14	Ачигч машин Z-17AW	2
15	Бетон зуурагч машин	1
16	PZ-50 маркийн бетон шүршигч машин	1
17	Шахуурга, /нөөцөнд 1 ширхэг/	3
<b>Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж</b>		
1	MZG-50 маркийн чичиргээт тэжээгүүр	1
2	Хацарт бутлуур	1
3	ЗҮА1230 маркийн туузан дамжуулагч	1
4	TD75-500 маркийн туузан дамжуулагч	1
<b>Бусад тоног төхөөрөмж</b>		
1	Үйлчилгээний машин	3
2	Утгуурт ачигч	1

**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

3	Дизель цахилгаан үүсгүүр, 350кВт	1
4	Автосамосвал	2

**1.13. Гадаад болон дотоод тээвэр**

Тус уурхайгаас олборлосон хүдрээс металлургийн баяжмал болох ФК-75 маркийн бүхэллэг жонш гар аргаар ялган авч автомашин болон төмөр замаар тээвэрлэн БНХАУ-д экспортлохоор төсөлд тусгаж байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Говьшоо” ХХК-ийн Логийн уурхай, “Үнэн-Анд” ХХК-ийн Мануултын уурхай, “Аргатай” ХХК-ийн Улаан толгойн уурхай, Хөх дэлийн хайлуур жоншны уурхай, “Болор жонш” ХХК-ийн Зүүн Аргатайн уурхайнууд нийлэн гадаад тээврийн олон салаа зам гарахаас сэргийлэх, гадаад тээврийн тогтсон нэг маршруттай болох зорилгоор замыг засаж сайжруулсан. Мануултын хайлуур жоншны уурхайгаас Баянжаргалан сумын урдуур өнгөрөх Хөөт - Олон-Овоот өртөө (25-р өртөө) хоорондох сайжруулсан шороон зам хүртэл 31 км замыг засаж сайжруулсан.

**Авто тээвэр:** Мануултын хайлуур жоншны далд уурхайгаас Баянжаргалан сум, төмөр замын Олон-Овоот өртөө гэсэн маршрутаар нийт 100 км шороон замаар тээвэрлэнэ.

**Төмөр замын тээвэр:** Олон-Овоот өртөөнөөс улсын урд хил хүртэл тээвэрлэх зай 370 км төмөр замаар тээвэрлэнэ.

## **БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

### **2.1. Газарзүйн мужлалаар:**

Хэнтийн уулархаг мужаас говь руу шилжих намхан толгодлог бүсэд оршино. Газар зүйн хувьд намхан толгодтой хамгийн нам нь Сум уул 1123 м, хамгийн өндөр нь Хавирга уул 1439 м ба харьцангуй өндөр нь 10-20 м байна.

Усан сүлжээний хувьд тогтмол урсацтай гол горхигүй ба Гашуун булаг, Дэрст ус гэсэн булагтай. Харин томоохон хөндийнүүдэд /хотгорт/ хуурай тойрмуудтай. Эдгээр нь хааяа хурын усаар дүүргэгддэг.

### **2.2. Ус зүйн хувьд:**

Уурхайн талбай нь Монгол орны гидрогеологийн мужлалаар төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд говь хээрийн усан сүлжээ муу хөгжсөн мужид хамаарна. Тогтмол урсгал усгүй, хөндийнүүдэд давстай жижиг нуур, цөөрөм олонтой. Тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч нуур, тойром, худгийн усны түвшин өөрчлөгдөнө. Цас их унаж хайлах, үргэлжилсэн ширүүн бороотой үед хот хонхор газар, нуурууд нь устай болох ба хуурай сайрууд нь гол болж ус урсах, бороо хур татрахад усгүй болно. Хуртай үед үүссэн нуур, тойром нь хэдэн долоо хоногоос хэдэн сар устай байж хүн, мал ундаална. Хүн малын ундаанд худгийн усыг хэрэглэх бөгөөд худгуудыг хуурай сайр, хөндий, нуурын зах хавийг бараадуулан гаргасан байдаг. Худгийн усны гүний түвшин 1-2 м, заримдаа 5-7 м ба худгуудийн ундарга 200-6000 л/ц байдаг. Ихэнх тойрмууд байнгын тэжээгдлийн эхгүй, борооны усаар дүүргэгдсэн жижиг сав газруудтай холбоотой үүссэн. Нууруудын гүн 1.5-2 м-ээс хэтрэхгүй.

### **2.3. Хөрсний хувьд:**

Говь, хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Хөрсний давхарга сул хөгжсөн. Дунджаар шимт хөрсний зузаан нь 0.5-15см. Нам дор газар 5-10см байх ба гол төлөв шавранцар элсэнцэр хэлбэртэй байна. Тус районы ихэнх газар нь хад цохиотой элсэрхэг газар юм. Хөрс үүсэхэд хур тунадас, салхи ихээхэн үүрэгтэй. Салхи нь хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж ууршилтыг ихэсгэснээр хөрс хуурайшихад нөлөөлөөд зогсохгүй хөрсний өнгөн хэсгийг хийсгэж нүүлгэн, хөрс эвдэхэд ихээхэн нөлөөтэй. Хур бороо элбэг үед ургамлын бүрхэвч сайжирч хөрсний эвдрэл үүсэх нөхцөлийг багасгана.

### **2.4. Ургамлын хувьд:**

Бутлаг ургамал голлосон сийрэг өвсөн бүрхүүлтэй. Хойд говийн цөлөрхөг хээрийн мужийн монгол өвс, монгол өвс-хазаар өвст говирхог хээр боловч монгол өвс-таана монгол өвс бударганат хээрийн бүсэд багтана. Харгана, бударгана зэрэг бутлаг ургамал, таана хөмүүл, монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал ургадаг. Ургамал ерөнхийдөө сийрэг боловч тачирхан, тэжээллэг чанар сайтай учир бэлчээрийн багагүй ач холбогдолтой.

### **2.5. Ан амьтны хувьд:**

Туурайтнаас хамгийн их тархсан нь цагаан зээр бөгөөд намартаа нүүдэллэн ирдэг. Түүнчлэн аргал хар сүүлт байдаг. Жигүүртнээс сар, элээ, хэрээ, харцага, тогоруу, ногтруу шаазгай, хулан жороо, шар шувуу, өвөөлж, хэвлээр явагчдаас могой, гүрвэл, мэрэгчдээс шар сүүлт, алаг даага, тарвага (маш бага), махчин амьтдаас үнэг, хярс, мануул, багаар чоно, шавьж идэштнээс зараа зэрэг тохиолдоно.

## **2.6. Цаг агаарын хувьд:**

Эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай говийн бүсэд хамаарах ба салхины гол чиглэл баруун хойноос зүүн урагш, дундаж хурд 5-10м/сек, хавар, намрын хуурайшилттай үед заримдаа 20-30м/сек хүрдэг байна. Цаг уурын станцын мэдээгээр жилийн дундаж температур – 4<sup>0</sup>, өвөл хамгийн хүйтэн 12 сард –32.5<sup>0</sup> бөгөөд цасан бүрхүүлд эрт хучигдах ба томоохон хөндийнүүдэд цасны зузаан 1 м-ээс давдаг байна., зун хамгийн халуун 7 сард +30<sup>0</sup> хүрэх ба жилд унах хур тунадасны хэмжээ 80.5мм. Зуны улиралд хур тунадас харьцангуй элбэг хавар намрын улиралд хуурайдуу байдаг. Агаарын чийгшилт 50%, хавар, намрын хүчтэй салхитай, 30 м/сек хүртэл ширүүсэж шороон шуурга шуурдаг байна. Цаг уурын нэг онцлог шинж чанар нь хавар 4-р сард ихээхэн салхилдаг. Салхины хурд 15м/с байна.

## **2.7. Дэд бүтэц:**

Цахилгаан хангамжийн хувьд Чойроос Шивээ-Овоо хүртэл 110кВт-ийн шугам Шивээ Овоогоос Баянжаргалан сум хүртэл 35 кВт-ийн шугам, Баянжаргалан сумаас Өндөршил сум хүртэл 15кВт-ийн шугам, Баянжаргалан сумаас Логийн хайлуур жоншны уурхай хүртэл 10кВт-ийн шугам тус тус тавигдсан байдаг. Иймд Мануултын уурхай нь төвийн цахилгааны шугамд холбогдох боломжтой. Мөн тус сум нь үүрэн телефоны системд холбогдсон. Мануултын хайлуур жоншны уурхайд UNITEL, SKYTEL–ийн үүрэн телефоны сүлжээтэй.

## **2.8. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдал**

Баянжаргалан сум нь 1925 онд байгуулагдсан байна. Сум анх байгуулагдахад 200 гаруй өрх, 1000 шахам хүн амтай, 40 орчим мянган толгой малтай, засаг захиргааны нэгж нь 5 багтайгаар зохион байгуулагдан сумын захиргаа үйл ажиллагаагаа эхэлж байжээ. Баянжаргалан сумын төв нь Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төвөөсөө 150 км-т, Монголын төмөр замаас 80 км зайтай оршдог.

Баянжаргалан сум нь одоо 328.9 мян.км<sup>2</sup> газар нутагтай, засаг захиргааны хуваариар Аргатай (сумын төв), Шилийн гол, Энгэр-Ус гэсэн 3 багт хуваагдана. Тус сумын нутаг дэвсгэрт жонш, чулуун нүүрс, төмрийн хүдрийн уурхайнууд үйл ажиллагаа явуулдаг байна. Баянжаргалан сумын нийт хүн ам нь 2017 оны жилийн эцсийн байдлаар 1195 байсан байна.

### **БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

“Мануулт хайлуур жоншны ордыг ашиглах төсөл”-ийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээг БОННУ-ний тайланд дараах байдлаар ангилан тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ;
2. Гол сөрөг нөлөөллийн үнэлгээ.

Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үед байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх технологийн үе шатуудыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Далд уурхайн нэвтрэлтүүд;
2. Далд уурхайн олборлолтын үйл явц;
3. Хүдрийг бутлан ангилах, баяжуулах үйлдвэр;
4. Өрөмдлөг тэсэлгээний ажил, тэсрэх материалын агуулах;
5. Хуучин ил уурхай ба овоолгууд;
6. Уурхайн ашиглалтын зам ба талбай;
7. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам ба тээвэрлэх үйл явц;
8. Ажилчдын хотхон ба түүний ашиглалтын үйл ажиллагаа;
9. Хатуу ба шингэн хог хаягдлын цэг, талбай.

#### **3.1. Болзошгүй сөрөг нөлөөллүүд**

Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ил ба далд уурхайн малталтын үед аюулгүй ажиллагаа дүрэм зөрчигдөх, технологийн буруу ажиллагаанаас үүдэн хөрсний нуралт, гулгалт зэрэг осол аваар үүсэж болзошгүй
- Уурхайн захиргаанаас бүтээгдэхүүн тээвэрлэлтийн маршрутыг тогтоон баталж тэмдэгжүүлээгүй, баталсан маршрутаар хийгээгүйн улмаас олон салаа зам үүсэж болзошгүй
- Төслийн үйл ажиллагаанд хэрэглэж буй үйлдвэрлэлийн (тэсэлгээний ба бусад) болон ахуйн зориулалттай химийн бодисууд ямар нэгэн байдлаар асгарснаар газрын хэвлий болон түүний гадаргыг бохирдуулж болзошгүй;
- Уурхайн дотоод ба гадаад тээвэрлэлтийн үед их хэмжээний тоос дэгдэж ургамлан бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;
- Шатах тослох материалыг тээвэрлэх, юүлэх, хадгалалтын горим алдагдах үед асгаралт үүсч газрын гадарга хэвлийг бохирдуулах магадлалтай, машин, техникийн ашигласан тосыг буруу хадгалах зэрэг шалтгаанаас үүдэн алдагдан газрын гадарга бохирдуулж болзошгүй;
- Уурхайн хатуу хог хаягдлын цэгийг зохих стандартын дагуу байгуулаагүй, хог хаягдлыг зохих дүрмийн дагуу зайлуулж, устгаагүйн улмаас салхи, усаар зөөгдөн ойр орчмын газрын гадаргыг бохирдуулж болзошгүй.
- Ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын зохих дүрмийн дагуу зайлуулаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй.

Агаар орчин:

- Уурхайн үйл ажиллагааны үед үүсэх тоосны тархалт төсөл хэрэгжиж буй нутгийн агаарын чанарт бохирдол үзүүлж болзошгүй;

Амьтны аймаг:

- Шөнийн цагаар уурхайн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтад идэш гэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;
- Уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам нь үйл ажиллагаанаас амьтадын аймаг, тэдгээрийн амьдралын зүй тогтолд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй
- Болзошгүй галын аюул, осол аваарийн үед гарах үнсний дэгдэлт, хорт утааны тархалтад амьтад хордож болзошгүй зэрэг болно.

Хүний эрүүл мэнд:

- Уурхайн бүхий л үйл ажиллагаа нь “Ил болон далд уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон бусад дүрэм зааврын дагуу явагдах ёстой. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд нь аюул учирч болзошгүй;

**“Мануулт хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**3.2. Гол сөрөг нөлөөлөл**

*Хүснэгт 10. Төслөөс үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд /БОННУ-нд тусгагдсанаар/*

